



**ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН .8. ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ .ийн ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 13/04

Эрдэнэт

Г “Баян-Өндөр сумын иргэдийн
Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын
төрийн албан хаагчдын хөгжлийн дэд хөтөлбөр”-ийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.17 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын хөгжлийн дэд хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр баталж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг байгууллагын төсөв болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрт тусгаж, хэрэгжилтийн явц, үр дүнт жил бүрийн 12 дугаар сард багтаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг дарга (Б.Баасансүрэн)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Сумын иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын
2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн Ээлжит
XIII хурлын 11 дугаар тогтоолын хавсралт

**“БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗДТГ БОЛОН БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АЖЛЫН АЛБАНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ
ДЭМЖИХ ХӨГЖЛИЙН ДЭД ХӨТӨЛБӨР”**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Дэд хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 46-р зүйлийн 46.3, Төрийн албаны тухай хуулийн 55-р зүйлийн 55.3 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.1, 59.1.2, 59.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын I хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.4.1, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлого болон Төрийн албаны шинэчлэгдсэн хууль, Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Орхон аймгийн хөгжлийн цогц бодлого, Орхон аймгийн Засаг даргын 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын 3.3.26, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын II хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэлэлцүүлэх үйл ажиллагаа”-ны 5.4, Баян-Өндөр сумын Засаг даргын 2020-2024 оны “Үйл ажиллагааны хөтөлбөрийн 8-р зүйл зэрэг холбогдох бодлогын баримт бичгүүдийг үндэс болгов.

1.2. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.2.6-д “төрийн албан хаагчид тавигдах ес зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын II хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5.4-т “Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын I хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.4.1-т “чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн алба төлөвшүүлнэ” гэж тус тус заажээ. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлаас “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-д заасан төрийн бүтээмжийг сайжруулах зорилгын хүрээнд сумын хэмжээнд төрийн албанд ажиллаж буй албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн төлөвшлийг сайжруулах, нийгмийн асуудлыг дэмжих, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах үүднээс энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

1.3.Баян-Өндөр сумын хүн амын тоо өдөр ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа нь төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх, төрийн анхан шатанд иргэдэд үйлчлэх үйлчилгээний орчин үеийн арга барил нэвтрүүлэх, цаг хугацаа, орон зайнлас үл хамааран төрийн үйлчилгээг шат дамжлагагүй, шуурхай болгохын тулд орчин үеийн шинэ тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, сум орон нутагтаа сургалтын баазтай болж, дотоод болоод гадаадын мэргэшсэн багш, мэргэжилтнээр ажлын байран дахь сургалтыг тасралтгүй явуулан ур чадвартай албан хаагчдыг бэлдэх, тэдний нийгмийн асуудлыг шийдэх, материаллаг баазыг бэхжүүлж, ажиллах нөхцөлийг сайжруулах тогтворт суурьшилтай ажиллуулах шаардлага зүй ёсоор гарч ирж байна. Дээрх асуудлыг бодитой шийдвэрлэхэд нэг талаас төрийн үйлчилгээг авч буй үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлага, сэтгэл ханамж, хүний нөөцийн хөгжлийн чиг хандлага, нөгөө талаас тус суманд ажиллаж буй төрийн албан хаагчдыг дэмжих үйл ажиллагааны зохистой тэнцлийг хангах бодлого боловсруулах шаардлага нь хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

Хоёр. Өнөөгийн байдал

Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба болон Засаг даргын Тамгын газар нь үндсэн 137 ажилтан, албан хаагчтай. Үүнээс төрийн захиргаа-79, төрийн улс төрийн-29, төрийн үйлчилгээний-29 албан хаагч байна. Мөн төрийн анхан шатны нэгж болох 26 багтай, 28297 өрхийн 106371 хүн амд төрийн үйлчилгээг үзүүлж байна.

2.1 Ажиллагсдын хүйсийн харьцаагаар нь авч үзвэл:

- 35 буюу 25,5 хувь нь эрэгтэй,
- 102 буюу 74,4 хувь нь эмэгтэй албан хаагч байна.

Өрх толгойлсон албан хаагч 10 байна.

2.2 Насны бүлгээр авч үзвэл:

- 20-25 насныхан 6 буюу 4,4 хувь,
- 26-35 насныхан 62 буюу 45,2 хувь,
- 36-45 насныхан 45 буюу 32,8 хувь,
- 46-55 насныхан 19 буюу 13,9 хувь,
- 56-60 насныхан 5 буюу 3,6 хувийг тус тус эзэлж байна.
- Ажиллагсдын дийлэнх буюу 45,2 хувийг 26-35 насныхан эзэлж байна.

2.3 Боловсрол, мэргэжлийн зэргийн байдлаар нь авч үзвэл:

- ✓ 20 буюу 16 хувь нь магистр,
- ✓ 97 буюу 77,6 хувь нь бакалавр,
- ✓ 6 буюу 4,8 хувь нь дипломын дээд,
- ✓ 2 буюу 1,6 хувь нь техник мэргэжлийн болон бүрэн дунд боловсролтой байна.

2.4 Баян-Өндөр суманд ажилласан жилээр нь ангилж үзвэл:

- ✓ 2-с доош жил ажилласан 48 буюу 35 хувь

- ✓ 3-4 жил ажилласан 30 буюу 22 хувь
- ✓ 5-10 жил ажилласан 40 буюу 29,2 хувь
- ✓ 11-15 жил ажилласан 11 буюу 8 хувь
- ✓ 16-20 жил ажилласан 4 буюу 2,9 хувь
- ✓ 20-оос дээш жил ажилласан 4 буюу 2,9 хувийг тус тус эзэлж байна.

2.5 Гэр бүлийн байдал хүүхдийн насны ангиллаар авч үзвэл:

- 0-5 насны хүүхэдтэй-72 албан хаагч
- 6-12 насны хүүхэдтэй-89 албан хаагч
- 13-18 насны хүүхэдтэй-48 албан хаагч тус тус байна.

2.6 Сууцны төрлөөр нь авч үзвэл:

- ❖ Амины орон сууцанд-1,
- ❖ Орон сууцанд-56,
- ❖ Хашаа байшинд-54,
- ❖ Гэрт-11,
- ❖ Өөрийн гэсэн орон гэргүй хамаатан садныдаа амьдардаг-2,
- ❖ Өөрийн гэсэн орон гэргүй түрээсийн байранд амьдардаг-4,
- ❖ Бусдын сууцанд түрээс төлдөггүй-9 албан хаагч тус тус байна.

2.7 Гэр бүлийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл:

- Гэр бүлдээ ганцаараа хөдөлмөр эрхэлдэг-42 албан хаагч
- Эхнэр, нөхөр хоёулаа хөдөлмөр эрхэлдэг -95 албан хаагч (үүнд дан эхнэр нөхөр бус гэр бүлдээ аав нь зэж нь хөдөлмөр эрхэлдэг тохиолдлууд хамрагдсан болно)

2.8 Цалингийн хэмжээгээр нь ангилж үзвэл: 2023 онд

- 1,000,000-1,200,000 мянган төгрөгийн цалинг 101 албан хаагч
- 1,300,000-1,500,000 мянган төгрөгийн цалинг 29 албан хаагч
- 1,600,000- аас дээш төгрөгийн цалинтай 7 албан хаагч тус тус байна

2.9 Авч буй цалингийн урамшуулал, тэтгэмжийн хэмжээгээр авч үзвэл:

Төрийн алба хаасан хугацааны

- ✓ 5 хувийн нэмэгдлийг 27 буюу 22,8 хувь нь,
- ✓ 10 хувийн нэмэгдлийг 5 буюу 4,2 хувь нь,
- ✓ 15 хувийн нэмэгдлийг 5 буюу 4,2 хувь нь,
- ✓ 20 хувийн нэмэгдлийг 1 буюу 0,84 хувь нь,
- ✓ 25 хувийг 8 буюу 6,8 хувь нь тус тус авч байна.

Нийт албан хаагчдын 38,9 хувь нь л төрд ажилласан жилийн нэмэгдлийг авч байна. Мөн 2022 оны 9 дүгээр сард албан хаагчдаас авсан судалгаагаар бүх ажилчид 100% цалингийн болон ямар нэг төрлийн санхүүгийн зээлтэй байна. Нийт

ажиллагсдын 83 буюу 66,4 хувь нь амьжиргааны баталгаажих түвшингээс дээгүүр, 42 буюу 33,6 хувь нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой амьдарч байна.

2.10 Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын судалгаа:

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын албан хаагчдын 2022 онд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн 26 албан хаагч байна. Үүнийг тус тусд нь авч үзвэл:

- ✓ Цалингаас шалтгаалан-9
- ✓ Татварын хэлтэс-4
- ✓ ГБХЗГ-3
- ✓ Орхон аймгийн Шүүх-1
- ✓ Ерөнхий боловсролын сургууль-1
- ✓ Орхон аймгийн ЗДТГ-1
- ✓ Баян-Өндөр сумын ИТХ-1
- ✓ Эрдэнэт үйлдвэр-1
- ✓ Бизнес-2
- ✓ Хувийн шалтгаан-3

2.11 Баян-Өндөр сумын Төрийн албан хаагчдад олгосон тэтгэмж, тусlamж, шагнал, урамшуулал, ажиллах баталгааг хангахад зориулж:

- ✚ 2019 онд 38,952,0 мян.төгрөг
- ✚ 2020 онд 18,848,0 мян.төгрөг
- ✚ 2021 онд 42,707,0 мян.төгрөг
- ✚ 2022 онд 32,825,0 мян, төгрөг тус тус зарцуулсан байна. (өндөр настны тэтгэвэрт гарсан жилийн зарцуулалт өндөр дүнтэй байгаа болно)

Гурав. Зорилго, зорилт, хэрэгцээ шаардлага

3.1 Дэд хөтөлбөрийн зорилго:

Чадахуйн зарчимд сууринсан мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлж, бэхжүүлэхэд төрийн албан хаагчийн ажиллах нөхцөлийг тасралтгүй сайжруулж, сурх болон нийгмийн баталгааг хангах зорилтуудыг хэрэгжүүлсний үндсэн дээр төрийн албан хаагчийг тогтвортой суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

3.2 Дэд хөтөлбөрийн зорилт:

- 3.2.1 Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах
- 3.2.2 Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг ханган, тэднийг тогтвортой суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах боломжийг бүрдүүлэх.
- 3.3.3 Өөрчлөлт, хөгжлийн стратегитай уялдуулан төрийн албан хаагчийг тасралтгүй сургаж хөгжүүлэх гэсэн үндсэн З зорилтын хүрээнд хэрэгжинэ.

3.3 Дэд хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага:

Төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлт нь байгууллагын зорилт, чиг үүргээ мэдлэг чадвартай, мэргэшсэн төрийн албан хаагчдын хүчээр хэрэгжүүлж, иргэдэд чанартай, хүртээмжтэй, тэгш төрийн үйлчилгээг үзүүлэх хэрэгцээ, шаардлага юм.

Төрийн байгууллагын үр дүнтэй, хүртээмжтэй үйл ажиллагаа явуулах гол нөөц нь мэдлэг чадвартай, нийгмийн баталгаа нь хангагдсан албан хаагч бөгөөд гадаад, дотоод орчны байнгын өөрчлөлт нь цаг үргэлжид мэдлэг чадвараа дээшлүүлж байх хэрэгцээг бий болгож байна. Энэхүү төрийн чиг үүргийн хэрэгцээг хангахын тулд төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах асуудал чухал байр суурь эзэнэ.

Тулгарч буй асуудал, хэрэгцээ шаардлагыг авч үзвэл:

- 3.3.1 Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, асуудлыг нь шийдвэрлэх боломж, бололцоо, хөшүүрэг дутмаг
- 3.3.2 Албан хаагчдын цалин хөлс, хангамж бага, ажлын ачаалал хэт их байгаагаас үүдсэн тогтвортой суурьшилтай ажиллах боловсон хүчний хомдол
- 3.3.3 Шинэ залуу албан хаагчдын сурх, хөгжихөд үзүүлэх дэмжлэг бага
- 3.3.4 Албан хаагчдын эрүүл мэндийн асуудалд зарцуулагдах хөрөнгө мөнгө дутмаг
- 3.3.5 Орон гэр, нийгмийн баталгаагаа хангах хэрэгцээ их
- 3.3.6 Үр хүүхдээ сургах боловсрол олгох хэрэгцээ их байна.

Албан хаагчдын сурх болон ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг бодит тооцоо, судалгаанд үндэслэн тэгш хүртээмжтэй, ил тод шийдвэрлэснээр тэднийг үр бүтээлтэй, тогтвортой суурьшилтай, идэвхи санаачилгатай ажиллуулах үндсэн нөхцөл бүрдэнэ.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг ханган цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмжийн асуудлыг тухай бүрд нь олгохын зэрэгцээ ажиллагдын ажиллах нөхцөл болон орон сууцны нөхцөлийг сайжруулах, түрээсээр болон бусад хэлбэрээр орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх, бие бялдрыг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх арга хэмжээ авах зэргээр тэднийг тогтвортой суурьшилтай ажиллуулах нэн шаардлагатай байгаа юм.

Дөрөв. Хамрах хүрээ

- 4.1 Баян-Өндөр сумын ИТХ-ын ажлын албаны албан хаагч нар
- 4.2 Баян-Өндөр сумын ЗДТГ-ын ажилтан, албан хаагч нар тус тус хамаарна.

Тав. Хэрэгжүүлэх зарчим, хугацаа

5.1 Дэд хөтөлбөрийн зарчим:

- 5.1.1 Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, суралцах боломжийг бүрдүүлэхтэй холбогдсон асуудлыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд явуулна.
- 5.1.2 Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, суралцах боломжийг бүрдүүлэхтэй холбогдсон зарим асуудлыг аймаг, орон нутгийн төсвөөс зохицуулж болно.

- 5.1.3 Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, суралцах боломжийг бүрдүүлэх энэхүү хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйлчилгээ, авч буй арга хэмжээ нь төрийн албан хаагчдад үр нөлөө үзүүлсэн ашиг тустай бодитой үйлчилгээ байна.
- 5.1.4 Хөтөлбөрийн заалтад тусгагдсан төсөвт өртөг тухайн жилдээ зарцуулагдаагүй тохиолдолд бусад шаардлагатай заалтад шилжүүлэн зарцуулж болно.

5.2 Дэд хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа:

“Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албан хаагч, Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын хөгжлийн дэд хөтөлбөр”-ийг 2023-2026 оныг хүртэл хэрэгжүүлэх ба гарсан үр дүнгээс хамаарч цаашид үргэлжлүүлэх, эсэхийг Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэнэ.

Зургаа. Удирдлага, зохион байгуулалт

- 6.1 Дэд хөтөлбөрийг Баян-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.
- 6.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр боловсруулж сумын Засаг дарга батална.
- 6.3 Дэд хөтөлбөрийг сумын хэмжээнд зохион байгуулах үүргийг сумын Засаг дарга, түүний Тамгын газар хариуцан гүйцэтгэнэ.
- 6.4 Гүйцэтгэлийг хангуулах, зохицуулах, хамт олны оролцоог хангах ажлыг дотоод ажил хүний нөөцийн мэргэжилтэн хариуцна.
- 6.5 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, тайланг сумын Засаг даргын зөвлөлд танилцуулж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн жилийн эцсийн хэрэгжилтийн тайлантай хамтатган сумын ИТХ-д тайлагнана.

Долоо. Үйл ажиллагааны чиглэл, арга хэмжээ

7.1. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ ОРЧИН, НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

- 7.1.1 Ажилтан бүрийг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн /ХАБЭА/ шаардлага хангасан ажлын байр, албан өрөө тасалгаагаар хангах
- 7.1.2 Ажлын байрны агааржуулалт, халаалт дулаан болон цэвэрлэгээ үйлчилгээг хэвийн байлгах арга хэмжээг авах
- 7.1.3 Албан тасалгааг шаардлага хангасан тавилга, тоног төхөөрөмж, компьютер, бусад техник хэрэгсэл, харилцаа, холбоо мэдээллийн хэрэгсэл зэрэг дэвшилтэд техник, технологиор хангах
- 7.1.4 Байгууллагын техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, гал, ус, цахилгаан хангамжийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх
- 7.1.5 Ажлын байранд албан хаагчдын хүүхдийг тоглуулах, хичээл давтах, амрах зориулалт бүхий өрөөг бий болгох
- 7.1.6 Байгууллагын албан хаагчдын хөгжлийн өрөөг бий болгох /амралт чөлөөт цагаараа ном унших, шатар, даам, теннис тоглох г.м/
- 7.1.7 Багуудад ажиллаж буй нийгмийн ажилтнуудад иргэдтэй ганцаарчлан уулзах нөхцөл боломжоор хангах

7.2 ТӨӨРЧЛӨЛТ, ХӨГЖЛИЙН СТРАТЕГИТАЙ УЯЛДУУЛАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙГ ТАСРАЛТГҮЙ СУРГАЖ ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

- 7.2.1 Төрийн албаны мэргэшсэн албан хаагч бэлтгэх, төрийн албаны багц сургалтуудад сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх сургалтад холбогдох ажилтныг хамруулах
- 7.2.2 Дотоодын болон гадаадын орнуудад магистрантур, докторантурт суралцах тохиолдолд дэмжлэг үзүүлэх /дотоодод 3.000.000 төгрөг, гадаадад 5.000.000 төгрөг хүртэлх дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно/

Шалгуур:

- Тухайн ажилтан нь 5 болон түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх

Бүрдүүлэх материал:

- ❖ Өргөдөл
- ❖ Иргэний үнэмлэхний хуулбар
- ❖ Нийгмийн даатгалын лавлагаа /и-монголиагаас/
- ❖ Сургуулийн тодорхойлолт

- 7.2.3 Байгууллагад шинээр томилогдож буй албан хаагчдыг сургалтын гарын авлагаар хангах, зөвлөн туслах сургалтыг ажлын байран дээр зохион байгуулж хэвших
- 7.2.4 Бусад аймаг, сумдын төрийн байгууллагуудтай туршлага солилцох боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх

7.3 ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАН, ТЭДНИЙГ ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ, ҮР БҮТЭЭЛТЭЙ АЖИЛЛАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

- 7.3.1 Хүний нөөцийн төлөвлөлтөд үндэслэн мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн албан хаагчдыг тогтворт суурьшилтай ажиллуулахад чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- 7.3.2 Эрүүл мэндийн эрт илрүүлгээр урьдчилан сэргийлэх үзлэгт албан хаагчдыг хуульд заасан хугацаанд тогтмол хамруулах
- 7.3.3 Албан хаагч болон түүний эхнэр, нөхөр, төрсөн хүүхэд нь иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад болон дотоодод хүнд мэс засалд орох өндөр өртөг бүхий шинжилгээ хийлгэх, эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх /10.000.000 хүртэлх сая төгрөгийн дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно/

Шалгуур:

- Тухайн ажилтан нь 3 болон түүнээс дээш жил ажилласан байх

Бүрдүүлэх материал:

- ❖ Өргөдөл
- ❖ Иргэний үнэмлэхний хуулбар
- ❖ Нийгмийн даатгалын лавлагаа /и-монголиагаас/
- ❖ Гэрлэлтийн лавлагаа
- ❖ Төрсний гэрчилгээ
- ❖ Эмнэлгийн байгууллагын шийдвэр

- ❖ Төлбөрийн дүнгээс хамаарч олгох дэмжлэг өөрчлөгдөх /баримт/

7.3.4 Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон гамшиг, гэнэтийн ослын үед иргэний зориг гарган бусдын амь нас, эд хөрөнгийг авран хамгаалсан албан хаагчийг урамшуулах /500.000 төгрөгийн урамшуулалт олгоно/

Бүрдүүлэх материал:

- ❖ Иргэний үнэмлэхний хуулбар
- ❖ Нийгмийн даатгалын лавлагаа /и-монголиагаас/
- ❖ Нотлох бичиг баримтууд

7.3.5 Өрх толгойлсон албан хаагчид дэмжлэг олгох /хөтөлбөрийн хугацаанд нэг удаа 500.000 төгрөгийн дэмжлэг олгоно/

Шалгуур:

- Тухайн ажилтан нь 3 болон түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх

Бүрдүүлэх материал:

- ❖ Өргөдөл
- ❖ Иргэний үнэмлэхний хуулбар
- ❖ Нийгмийн даатгалын лавлагаа /и-монголиагаас/
- ❖ Холбогдох бичиг баримт

7.3.6 Баян-Өндөр сумандaa анх удаа орон сууц, амины орон сууц барьж байгаа болон худалдан авч буй албан хаагчид дэмжлэг үзүүлэх /10.000.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно.

Жич: Хуучин үл хөдлөх хөрөнгөө шинээр гэрчилгээжүүлж байгаа бол тооцохгүй. Амины орон сууцыг орон сууцтай адилтгаж ойлгоно./

Шалгуур:

- Тухайн ажилтан нь 5 болон түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх

Бүрдүүлэх материал:

- ❖ Өргөдөл
- ❖ Иргэний үнэмлэхний хуулбар
- ❖ Нийгмийн даатгалын лавлагаа /и-монголиагаас/
- ❖ Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа /эхнэр, нөхөр/
- ❖ Газрын гэрчилгээний хуулбар
- ❖ Худалдан авч буй гэрээ, нотлох бичиг баримт

7.3.7 Баян-Өндөр сумандaa анх удаа сууцны тусдаа байшин барьж байгаа болон худалдан авч буй албан хаагчид дэмжлэг үзүүлэх /5.000.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно.

Жич: Хуучин үл хөдлөх хөрөнгөө шинээр гэрчилгээжүүлж байгаа бол тооцохгүй./

Шалгуур:

- Тухайн ажилтан нь 5 болон түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх

Бүрдүүлэх материал:

- ❖ Өргөдөл
- ❖ Иргэний үнэмлэхний хуулбар
- ❖ Нийгмийн даатгалын лавлагаа /и-монголиагаас/
- ❖ Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа /эхнэр, нөхөр/
- ❖ Газрын гэрчилгээний хуулбар
- ❖ Худалдан авч буй гэрээ, нотлох бичиг баримт

7.3.8 Байшингийнхаа халаалтын эх үүсвэрээ бүрэн шийдвэрлэж яндангийн тоог цөөлсөн албан хаагчид дэмжлэг үзүүлэх /3.000.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно/

Шалгуур:

- Тухайн ажилтан нь 5 болон түүнээс дээш жил ажилласан байх

Бүрдүүлэх материал:

- ❖ Өргөдөл
- ❖ Иргэний үнэмлэхний хуулбар
- ❖ Нийгмийн даатгалын лавлагаа /и-монголиагаас/
- ❖ Нотлох бичиг баримт

7.3.9 Албан хаагчийн төрсөн хүүхэд нь магадлан итгэмжлэгдсэн улсын болон хувийн их, дээд сургуульд суралцдаг бол хүүхдийн тооноос үл хамааран дэмжлэг үзүүлэх /доорх дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно/

Шалгуур:

- Тухайн ажилтан нь 3-5 жил тасралтгүй ажилласан бол 1.000.000 төгрөг
- Тухайн ажилтан нь 6-9 жил тасралтгүй ажилласан бол 2.000.000 төгрөг
- Тухайн ажилтан нь 10 болон түүнээс дээш жил тасралтгүй ажилласан бол 3.000.000 төгрөг

Бүрдүүлэх материал:

- ❖ Өргөдөл
- ❖ Иргэний үнэмлэхний хуулбар
- ❖ Нийгмийн даатгалын лавлагаа /и-монголиагаас/
- ❖ Хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар
- ❖ Хүүхдийн сургуулийн тодорхойлолт
- ❖ Төлбөр төлсөн баримт, дүнгийн хуулбар

7.3.10 Байгууллагын албан хаагч болон албан хаагчийн төрсөн хүүхэд /6-18 нас/ нь улсын болон олон улсын чанартай тэмцээн уралдаанд эх орноо төлөөлөн багийн болон ганцаарилсан төрөлд оролцож 1-3 дугаар байранд шалгарсан тохиолдолд урамшуулал олгох /доорх дэмжлэгийг хөтөлбөр хэрэгжих хугацаанд нэг удаа олгоно/

Шалгуур:

- Улсын чанартай тэмцээн уралдаанд 500.000 төгрөг
- Олон улсын чанартай тэмцээн уралдаанд 1.000.000 төгрөг

Бүрдүүлэх материал:

- ❖ Өргөдөл
- ❖ Иргэний үнэмлэхний хуулбар
- ❖ Нийгмийн даатгалын лавлагаа /и-монголиагаас/
- ❖ Төрсний гэрчилгээний хуулбар
- ❖ Нотлох бичиг баримтууд

7.3.11 Тухайн албан хаагч өөрөө болон гэр бүлийн хүн нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдалт нь тогтоогдсон бол дэмжлэг үзүүлэх /1.000.000 төгрөгийн дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно/

Бүрдүүлэх материал:

- ❖ Өргөдөл
- ❖ Иргэний үнэмлэхний хуулбар
- ❖ Нийгмийн даатгалын лавлагаа /и-монголиагаас/
- ❖ Нотлох бичиг баримтууд

7.3.12 Шинэ санал, санаачлага гарган инновацид суурилсан шинэлэг арга барил ажилдаа нэвтрүүлэн үр дүн, үр нөлөө гарган ажилласан албан хаагчийг урамшуулах /300.000 төгрөгийн урамшууллыг санаачилга гаргасан тохиолдол бүрд олгоно/

Бүрдүүлэх материал:

- ❖ Өргөдөл
- ❖ Иргэний үнэмлэхний хуулбар

- ❖ Нийгмийн даатгалын лавлагаа /и-монголиагаас/
- ❖ Ажлын тайлан

Найм. Хүрэх үр дүн

- 8.1 Төрийн албан хаагчийн сурх болон ажиллах орчин, нөхцөлийг сайжруулснаар ажлын байрны сэтгэл ханамжийн түвшин нэмэгдэнэ.
- 8.2 Төрийн албан хаагч тогтвортой суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах боломжийг бүрдүүлснээр төр, орон нутгийн бодлого, шийдвэрийн үр дүн, хэрэгжилт сайжирна.
- 8.3 Төрийн болон байгууллагын өөрчлөлт, хөгжлийн стратегитай уялдуулан шинэ мэдээ, мэдээлэл бүхий суралцагч, ёс зүйтэй төрийн албан хаагчтай болсон байна.
- 8.4 Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчин бүрдсэн байна.
- 8.5 Албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдсанаар шийдэгдсэнээр ажилд хандах хандлага ажлын бүтээмж сайжирна.

Ес. Хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх

- 9.1 Сумын Засаг даргын Тамгын газрын ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ нэгж нь хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд үнэлгээ хийж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг сумын Засаг даргын зөвлөлд танилцуулна.
- 9.2 Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст жил бүр хүргүүлнэ.
- 9.3 Хөтөлбөрийн үр дүн санхүүгийн тайлан мэдээллийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн жилийн эцсийн хэрэгжилтийн тайлантай хамтатган сумын ИТХ-д тайлагнана.

Арав. Санхүүжилт

10.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 10.2.1 Орон нутгийн төсөв
- 10.2.2 Гадаад улс, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр
- 10.2.3 Аж ахуйн нэгж байгууллага, ТББ-ын санхүүгийн дэмжлэг
- 10.2.4 Бусад

Арван нэг. Шалгуур үзүүлэлт

11.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2022 он)	Хүрэх түвшин (2026)
-------------	------------------	---------------------------	------------------------

Зорилт1: Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах			
7.1.1. Ажилтан бүрийг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн /ХАБЭА/ шаардлага хангасан ажлын байр, албан өрөө тасалгаагаар хангах	Ханган ажилласан байдал		Бүх албан хаагчид шаардлага хангасан өрөө тасалгаагаар хангагдсан байна.
7.1.2. Ажлын байрны агааржуулалт, халаалт дулаан болон цэвэрлэгээ үйлчилгээг хэвийн байлгах арга хэмжээг авах	Ажлын байрны агааржуулалт, халаалт дулаан болон цэвэрлэгээ үйлчилгээг хэвийн байлгахад анхаарч ажилласан байдал		Цэвэрлэгээ үйлчилгээг хэвийн байлгахад анхаарч ажиллах
7.1.3. Албан тасалгааг шаардлага хангасан тавилга, тоног төхөөрөмж, компьютер, бусад техник хэрэгсэл, харилцаа, холбоо мэдээллийн хэрэгсэл зэрэг дэвшилтэд техник, технологиор хангах	шаардлага хангасан тавилга, тоног төхөөрөмж, компьютер, бусад техник хэрэгсэл, харилцаа, холбоо мэдээллийн хэрэгсэл зэрэг дэвшилтэд техник, технологиор хангасан байх		Төсвийн хүрээнд шаардлагатай эд хогшлоор ханган ажиллана
7.1.4. Байгууллагын техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, гал, ус, цахилгаан хангамжийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлсэн байх		Шаардлагата й дэмжлэгийг үзүүлэн ажиллана
7.1.5 Ажлын байранд албан хаагчдын хүүхдийг тоглуулах, хичээл давтах, амрах зориулалт бүхий өрөөг бий болгох	Шинээр өрөө бий болгож, тохижуулсан байх		шинээр өрөө бий болгож, тохижуулна.
7.1.6. Байгууллагын албан хаагчдын хөгжлийн өрөөг бий болгох	Шинээр өрөө бий болгож, тохижуулсан байх		шинээр өрөө бий болгож, тохижуулна.
7.1.7. Багуудад ажиллаж буй нийгмийн ажилтнуудад иргэдтэй ганцаарчлан	Нөхцөл боломжоор ханган ажилласан байдал		Шинээр өрөө бий болгож, тохижуулсан байна

уулзах нөхцөл боломжоор хангах			
Зорилт 2: Өөрчлөлт, хөгжлийн стратегитай уялдуулан төрийн албан хаагчийг тасралтгүй сургаж хөгжүүлэх зорилтын хүрээнд			
7.2.1. Төрийн албаны мэргэшсэн албан хаагч бэлтгэх, төрийн албаны багц сургалтуудад сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх сургалтад холбогдох ажилтныг хамруулах	Албан хаагчийг хамруулсан эсэх		Хөтөлбөрийн дагуу шаардлагтай албан хаагчийг хамруулан ажиллана
7.2.2. Дотоодын болон гадаадын орнуудад магистрантур, докторантурт сургалцах тохиолдолд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлсэн байх		Хөтөлбөрийн дагуу шаардлагтай албан хаагчадад дэмжлэг үзүүлэн ажиллана
7.2.3. Байгууллагад шинээр томилогдож буй албан хаагчдыг сургалтын гарын авлагаар хангах, зөвлөн туслах сургалтыг ажлын байран дээр зохион байгуулж хэвших	Хамрагдсан албан хаагчдын тоо, гарсан үр дүн		Шинээр томилогдсон албан хаагчдад анхан шатны сургалт зөвлөгөө өгч хэвшсэн байна
7.2.4. Бусад аймаг, сумдын төрийн байгууллагуудтай туршлага солилцох боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх	Туршлага солилцох үйл ажиллагааг дэмжин ажилласан байх хамрагдсан албан хаагчдын тоо, гарсан үр дүн		Туршлага солилцох үйл ажиллагаанд албан хаагчдыг хамруулан үр дүнг тооцон ажиллана
Зорилт 3: Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг ханган, тэднийг тогтворт суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах боломжийг бүрдүүлэх			
7.3.1. Хүний нөөцийн төлөвлөлтэд үндэслэн мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн албан хаагчдыг тогтворт суурьшилтай ажиллуулахад чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Тогтворт суурьшилтай ажиллуулахад чиглэсэн үйл ажиллагааны үр дүн, албан хаагчдын тогтворт суурьшил нэмэгдсэн байх	2022 онд 26 албан хаагч	Тогтворт суурьшилтай ажиллуулахад чиглэсэн арга хэмжээ авч шилжилт албан хаагчдын солигдох

			байдлыг багасгасан байна.
7.3.2. Эрүүл мэндийн эрт илрүүлгээр урьдчилан сэргийлэх үзлэгт албан хаагчдыг хуульд заасан хугацаанд тогтмол хамруулах	Хамруулсан албан хаагчдын тоо, хувь	78 албан хаагч буюу 66,1%	Албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулсан байна.
7.3.3. Албан хаагч болон түүний эхнэр, нөхөр, төрсөн хүүхэд нь иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн өмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад болон дотоодод хүнд мэс засалд орох өндөр өртөг бүхий шинжилгээ хийлгэх, эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд өмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх /10.000.000 хүртэлх сая төгрөгийн дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно/	Албан хаагчийг хамруулсан эсэх		Хөтөлбөрийн дагуу шаардлагтай албан хаагчийг хамруулан ажиллана
7.3.4. Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон гамшиг, гэнэтийн ослын үед иргэний зориг гарган бусдын амь нас, эд хөрөнгийг авран хамгаалсан албан хаагчийг урамшуулах /Хөтөлбөрийн хугацаанд 1 удаа 500.000 төгрөгийн урамшуулал олгоно/	Хамрагдсан албан хаагчийн тоо		Хөтөлбөрийн дагуу шаардлагтай албан хаагчийг хамруулан ажиллана
7.3.5. Өрх толгойлсон албан хаагчид дэмжлэг олгох /хөтөлбөрийн хугацаанд жилд нэг удаа	Хөтөлбөрт тусгасны дагуу хамруулсан байдал		Заалтад нийцсэн албан хаагчдыг хамруулсан байх

500.000 төгрөгийн дэмжлэг олгоно/			
7.3.6. Баян-Өндөр сумандаа анх удаа орон сууц, амины орон сууц барьж байгаа болон худалдан авч буй албан хаагчид дэмжлэг үзүүлэх /10.000.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно. Жич: Хуучин үл хөдлөх хөрөнгөө шинээр гэрчилгээжүүлж байгаа бол тооцохгүй. Амины орон сууцыг орон сууцтай адилтгаж ойлгоно./	Хөтөлбөрт заасны дагуу хамруулсан байдал	Хөтөлбөрийн дагуу шалгуурыг хангасан албан хаагчдыг хамруулан ажиллана	
7.3.7. Баян-Өндөр сумандаа анх удаа сууцны тусдаа байшин барьж байгаа болон худалдан авч буй албан хаагчид дэмжлэг үзүүлэх /5.000.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно. Жич: Хуучин үл хөдлөх хөрөнгөө шинээр гэрчилгээжүүлж байгаа бол тооцохгүй./	Хөтөлбөрийн дагуу олгосон эсэх	Хөтөлбөрийн дагуу шалгуурыг хангасан албан хаагчдыг хамруулан ажиллана	
7.3.8. Байшигийнхаа халаалтын эх үүсвэрээ бүрэн шийдвэрлэж яндангийн тоог цөөлсөн албан хаагчид дэмжлэг үзүүлэх /3.000.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно/	Шаардлага хангасан албан хаагчийг хамруулсан байдал	Шаардлага хангасан албан хаагчийг хамруулан ажиллана.	
7.3.9. Албан хаагчийн төрсөн хүүхэд нь магадлан итгэмжлэгдсэн улсын болон хувийн их, дээд сургуульд суралцдаг бол хүүхдийн тооноос үл хамааран дэмжлэг үзүүлэх /доорх	Хамрагдсан албан хаагчийн тоо	2022 оны байдлаар 9 албан хаагч байна цаашид нэмэгдэх	Хөтөлбөрт туссан шалгуурыг хангасан бүх албан хаагчдыг

дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно/		боломжто й	хамруусан байх
7.3.10. Байгууллагын албан хаагч болон албан хаагчийн төрсөн хүүхэд /6-18 нас/ нь улсын болон олон улсын чанартай тэмцээн уралдаанд эх орноо төлөөлөн багийн болон ганцаарилсан төрөлд оролцож 1-3 дугаар байранд шалгарсан тохиолдолд урамшуулалт олгох /доорх дэмжлэгийг хөтөлбөр хэрэгжих хугацаанд нэг удаа олгоно/	Хөтөлбөрийн дагуу олгосон эсэх		Хөтөлбөрийн дагуу шалгуурыг хангасан албан хаагчдыг хамруулан ажиллана
7.3.11. Тухайн албан хаагч өөрөө болон гэр бүлийн хүн нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдалт нь тогтоогдсон бол дэмжлэг үзүүлэх /1.000.000 төгрөгийн дэмжлэгийг хөтөлбөрийн хугацаанд нэг удаа олгоно/	Хөтөлбөрийн дагуу олгосон эсэх		Хөтөлбөрийн дагуу шалгуурыг хангасан албан хаагчдыг хамруулан ажиллана
7.3.12. Шинэ санал, санаачлага гарган инновацид сууринласан шинэлэг арга барил ажилдаа нэвтрүүлэн үр дүн, үр нөлөө гарган ажилласан албан хаагчийг урамшуулах /300.000 төгрөгийн урамшууллыг санаачилга гаргасан тохиолдол бүрд олгоно/	шинэ санал, санаачлага гарган ажилласан шинэлэг арга барил ажилдаа нэвтрүүлэн үр дүн, үр нөлөө гарган ажилласан албан хаагчийг урамшуулах /300.000 төгрөгийн урамшууллыг санаачилга гаргасан тохиолдол бүрд олгоно/		Хөтөлбөрийн хугацаанд шаардлага хагасан албан хаагчийг дэмжин ажиллах

---оо---